

Дархан Уул аймаг Дархан сум Өргөө баг



# “БАГИЙН НОГООН БАЙГУУЛАМЖ НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСӨЛ

Төслийн нэр: Ногоон Өргөө

Төсөл хэрэгжих байршил: Дархан-Уул аймаг, Дархан сум,  
Өргөө баг 21,22 дугаар хороолол дотор

2026 ОН

## АГУУЛГА

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн үндэслэл
3. Төслийн зорилго, зорилтууд
4. Хэрэгжүүлэх хугацаа, үе шатууд
5. Төсөв, эдийн засгийн тооцоо
6. Төслийн үр дүн, ач холбогдол
7. Төслийн үйл ажиллагааг тайлагнах

### 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	Моджуулах төсөл
Төслийн бүтэц	21,22 дугаар хороолол доторх талбайг зүлэгжүүлэх, моджуулах
Хөтөлбөр хэрэгжүүлэх байршил	Дархан сум, Өргөө баг
Төсөл санаачлагч	Дархан-Уул аймгийн ИТХ-ын төлөөлөгч
Төслийн шим хүртэгчид	Дархан сумын Өргөө багийн 21, 22 дугаар хороолол дотор
Санхүүжилтийн эх үүсвэр	Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар
Төслийн нийт төсөв	12,194,000 төгрөг
Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2026 оны 2 дугаар улирал

Холбогдох ажилтан: Засаг дарга Э.Бумантуяа / 99052344, 70372017 /

Хаяг байршил: Дархан Уул аймаг Дархан сум 5-р баг 4,5,Өргөө багийн төв

Facebook хаяг: Дархан сум Өргөө баг

## 2. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дархан сумын Өргөө багийн 21,22 дугаар хороолол дотор моджуулах нь цэвэр агаарт хүүхдүүдээ салхилуулах алхалт хийх чөлөөт цагийн үр бүтээлтэй зөв өнгөрүүлэх, цэвэр аюулгүй орчин нөхцөл бүрдүүлэхэд нэн шаардлагатай байгаа нь төсөл бичих үндэслэл болов.

Мод тарих нь агаар цэвэршүүлэх, хөрс бэхжүүлэх, орчны гоо зүйг сайжруулах, иргэдийн эрүүл тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой учраас энэ төслийг өргөн барьж байна.

## 3. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Орон сууцны орчны ногоон байгууламжаар нэмэгдүүлж, агаарын бохирдлыг бууруулах, оршин суугчдын эрүүл аюулгүй, таатай амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэн мод тарьж, арчлан хамгаалах.

## 4. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТУУД

№	Төслийн үе шат	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төслийг бичих	Мод тарих талбайн судалгааг хийж, төслийг бичих	2026.02	Санаачлагч Дархан сумын ИТХ-ын төлөөлөгч
2	Ажлын зураг, төсвийг гаргах	Холбогдох ажлын зураг, шаардлагатай ажлын тоо хэмжээг багтаасан төсвийг бэлтгэх	2026.03	Дархан сум ЗДТГ
3	Төслийг хэрэгжүүлэх	Төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээний дагуу мод суулгац суулгах ажлыг хийж гүйцэтгэх	2026.04	Гүйцэтгэгч байгууллага
4	Төслийн ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх, хүлээн авах	Төслийг ашиглалтад хүлээн авах комисс ажиллана.	2026.05	Багийн Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч Гүйцэтгэгч байгууллага

## 5.ТӨСӨВ, ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

№	Хийгдэх жил	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Шаардлагатай материалын зураг
1	Мод суулгац /Гацуур /	0.6-0.7 см өндөр	78	80000	6240000	
2	Мод суулгац / Нарс /	0.6-.0.7 см өндөр	70	80000	5600000	
3	Зүлэгжүүлэлт /2100 м2 талбайд /		6,436 кг	55000	354000	
<b>Нийт дүн</b>					<b>12.194.000</b>	

## 6.ТӨСЛИЙН ҮР ДҮН АЧ ХОЛБОГДОЛ

- ✓ Орон сууцны орчны ногоон байгууламж нэмэгдэнэ.
- ✓ Агаарын бохирдол тодорхой хэмжээгээр буурна.
- ✓ Оршин суугчдын амьдрах орчин илүү цэвэр таатай болно.
- ✓ Хүүхэд, иргэд амрах, тоглох эко орчин бүрдэнэ.
- ✓ Иргэдийн мод тарих, арчлах мэдлэг хандлага сайжирна.
- ✓ Хөршийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулна.
- ✓ Ирээдүйд тогтвортой, ногоон хөгжлийн суурь болно.

## 7.ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАЙЛАГНАХ

Төсөл нь 2 сарын хугацаанд хэрэгжих бөгөөд тус төслийг ашиглалтад хүлээн авах комисс ажилласны дараа хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан нийтэд ил тод мэдээлнэ.

- 1) Төслийн ажлын гүйцэтгэлийн тайлан /фото зургийн хамт/
- 2) Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа

Модны жишиг үнэлгээ

№	Нэр төрөл үзүүлэлт	Шаардлага
1	Байршил	Дархан Уул аймаг Дархан сум Өргөө баг, 21,22-р хороолол дотор 0,39 км газар
2	Материал	Нарс болон гацуур нь суулгац болон бортоготой байна.
3	Стандарт	Мод нь Монгол улсад мөрдөж буй стандартын шаардлага, аюулгүй байдлыг хангасан байна.
4	Суурилуулалт	3 м тутамд нэг мод байрлах
5	Зүлэгжүүлэлт	Дархан Уул аймаг Дархан сум Өргөө баг, 21,22-р хороолол дотор 2100 м2 талбайд

Жич: Төсөв болон Төсөл хэрэгжих талбайн зургийг хавсаргав

### Жаргалант Өргөө СӨХ



Нарлаг Өргөө СӨХ



Оч СӨХ



ТӨСӨЛ БИЧСЭН: БАГИЙН ЗАСАГ ДАРГА Э.БУМАНТУЯА